

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Д.БУЯНДЭЛГЭР ТАНАА

2021.08.25 № 07/480
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үйлдвэрлэл Урлалын политехникийн коллежийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үйлдвэрлэл Урлалын политехникийн коллежийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ДАНС	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	446,535,035.43	365,445,441.30
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
311	Кассад байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	93,907,519.13	52,175,012.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	12.00
335	Бусад авлага	93,907,519.13	52,175,000.00
3351	Байгууллагаас авах авлага	2,516,519.13	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	91,391,000.00	52,175,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	-
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	352,627,516.30	313,270,429.30
351	Түүхий эд материал	263,463,897.00	244,919,920.00
35110	Тусгай зориулалттай материал	263,463,897.00	244,919,920.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	14,601,103.00	13,301,103.00
354	Хангамжийн материал	73,767,516.30	55,049,406.30
35410	Бичиг хэргийн материал	534,800.00	333,300.00
35420	Аж ахуйн материал	43,552,537.90	29,437,017.90
35430	Сэлбэг хэрэгсэл	3,133,188.40	531,088.40
35460	Бусад хангамжийн материал	26,546,990.00	24,748,000.00
35600	Мал, амьтад	795,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,472,635,979.35	6,956,592,209.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,472,635,979.35	6,956,592,209.38
392	Биет хөрөнгө	7,202,906,135.50	6,691,632,209.38
39201	Барилга, байгууламж	5,695,485,810.33	5,772,165,810.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	(94,924,763.52)	(189,849,527.04)
39203	Авто тээврийн хэрэгсэл	111,610,000.00	111,610,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(77,166,778.03)	(86,690,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	3,804,697,066.81	3,784,022,809.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,920,316,703.20)	(3,287,443,857.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	663,394,731.39	667,439,731.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	(428,380,586.93)	(482,788,725.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө	334,251,182.55	334,251,182.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	(68,360,220.39)	(113,901,611.29)
39217	Номын фонд	182,616,396.49	182,816,396.49
393	Биет бус хөрөнгө	269,729,843.85	264,960,000.00
39301	Программ хангамж	68,019,784.83	61,937,369.86
39302	Хасагдуулаг	(63,249,940.98)	(61,937,369.86)
39303	Газар эзэмших эрх	264,960,000.00	264,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,919,171,014.78	7,322,037,650.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	7,919,171,014.78	7,322,037,650.68
51	Засгийн газрын хувь оролцоо	7,919,171,014.78	7,322,037,650.68
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	2,939,702,673.59	2,939,702,673.59
51101	Өмч: -Төрийн өмч	2,939,702,673.59	2,939,702,673.59
512	Хуримтлагдсан үр дүн	(475,765,183.98)	(1,072,898,548.08)
51210	Өмнөх үеийн үр дүн	(475,765,183.98)	(475,765,183.98)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(597,133,364.10)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,455,233,525.17	5,455,233,525.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	7,919,171,014.78	7,322,037,650.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			Төгрөгөөр
ДАНС	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,019,405,245.00	2,824,457,242.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	583,219,845.00	249,622,742.59
120	Нийтлэг татварын бус орлого	583,219,845.00	249,622,742.59
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	583,219,845.00	249,622,742.59
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	336,153,520.00	204,271,790.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,152,385.00	11,204,952.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	167,913,940.00	34,146,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,436,185,400.00	2,574,834,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,350,641,900.00	2,560,689,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,350,641,900.00	2,560,689,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,543,500.00	14,145,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,543,500.00	14,145,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,317,304,046.74	3,420,197,039.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,317,304,046.74	3,420,197,039.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,189,886,042.50	3,276,134,461.85
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,788,135,181.74	2,025,561,625.60
210101	Цалин	1,508,567,909.74	1,565,314,875.58
210102	Нэмэгдэл цалин	183,540,472.00	207,842,850.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,930,400.00	37,243,859.65
210104	Урамшуулал	55,096,400.00	215,160,040.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,054,989.81	263,418,951.88
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	188,088,289.81	230,873,448.33
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	10,491,700.00	6,101,391.09
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,393,500.00	7,134,192.33
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,098,300.00	1,755,447.21
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	20,983,200.00	17,554,472.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,332,893.09	83,976,499.76
210301	Гэрэл цахилгааны зардал	51,850,239.56	32,429,914.62
210302	Түлш, халаалтын зардал	63,583,958.19	34,058,218.81
210303	Цэвэр, бохир усны зардал	3,898,695.34	17,488,366.33
2104	Хангамж, бараа материалын зардал	13,115,068.29	14,775,220.00
210401	Бичиг хэргийн материал	3,950,000.00	417,531.00
210402	Тээвэр, шатахууны зардал	6,805,068.29	1,750,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	2,360,000.00	8,162,689.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	4,445,000.00
2105	Нормативт зардал	77,214,510.00	50,499,680.00
210501	Эм	-	330,000.00
210502	Хоол	77,214,510.00	50,169,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,658,134.00	5,835,000.00
210601	Багаж хэрэгсэл	13,560,020.00	-
210604	Урсгал засвар	27,098,114.00	5,835,000.00
2107	Томиллолт, зочны зардал	2,710,200.00	-
210702	Дотоод томилолтын зардал	2,710,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	55,149,156.00	56,346,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,700,000.00	47,100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	3,200,000.00	5,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	1,583,156.00	2,634,156.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,000.00	462,230.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	470,000.00	882,750.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	-	66,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	863,515,909.57	775,721,468.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,897,160.00	-
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	200,007,572.00	147,960,266.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	602,611,177.57	627,761,202.61

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,418,004.24	144,062,577.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,144,827.00	65,870,150.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	54,863,720.00	5,856,980.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,141,900.00	56,768,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,139,207.00	3,244,370.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,273,177.24	78,192,427.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,273,177.24	78,192,427.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(297,898,801.74)	(595,739,796.74)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	309,151,755.00	1,393,567.36
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	309,151,755.00	1,393,567.36
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(309,151,755.00)	(1,393,567.36)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(607,050,556.74)	(597,133,364.10)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		Төгрөгөөр	
ДАНС	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,759,680,646.00	2,828,873,990.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	323,495,246.00	254,039,490.00
120	Нийтлэг татварын бус орлого	323,495,246.00	254,039,490.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	250,756,306.00	254,039,490.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	244,762,520.00	243,487,790.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,993,786.00	10,551,700.00
120009	Бусад орлого	72,738,940.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,436,185,400.00	2,574,834,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,350,641,900.00	2,560,689,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,350,641,900.00	2,560,689,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,543,500.00	14,145,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,543,500.00	14,145,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,729,615,546.00	2,749,908,990.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,729,615,546.00	2,749,908,990.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,602,197,541.76	2,605,846,412.52
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,804,516,242.38	2,009,231,705.76
210101	Үндсэн цалин	1,241,499,442.38	1,096,809,319.15
210102	Нэмэгдэл	363,056,900.00	562,994,086.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,863,500.00	79,171,859.65
210104	Үр дүнгийн урамшуулал	122,096,400.00	270,256,440.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	225,607,700.00	276,579,100.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	153,413,300.00	194,629,700.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	18,048,600.00	20,487,300.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	14,438,900.00	16,389,900.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	3,609,700.00	4,097,500.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	36,097,200.00	40,974,700.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	119,332,893.09	83,976,499.76
210301	Гэрэл цахилгааны зардал	51,850,239.56	32,429,914.62
210302	Түлш, халаалтын зардал	63,583,958.19	34,058,218.81
210303	Цэвэр, бохир усны зардал	3,898,695.34	17,488,366.33
2104	Хангамж, бараа материалын зардал	23,800,326.29	28,631,966.00
210401	Бичиг хэрэг	3,789,200.00	3,062,931.00
210402	Тээвэр, шатахуун	4,650,000.00	3,105,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,805,068.29	8,455,689.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,360,000.00	9,389,404.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,196,058.00	4,618,942.00
2105	Нормативт зардал	88,974,005.00	56,990,900.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	115,500.00	1,346,130.00
210502	Хоол, хүнс	77,214,510.00	50,169,680.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,643,995.00	5,475,090.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,409,764.00	12,923,229.00
210601	Багаж техник хэрэгсэл	16,400,520.00	1,766,279.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,298,500.00	3,962,500.00
210604	Урсгал засвар	41,710,744.00	7,194,450.00
2107	Томиллолт, зочны зардал	2,710,200.00	-
210702	Дотоод албан томилолт	2,710,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,149,156.00	56,279,136.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	49,700,000.00	47,100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,200,000.00	5,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,583,156.00	2,634,156.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,000.00	462,230.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	470,000.00	882,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	220,697,255.00	81,233,876.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,748,940.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	152,948,315.00	81,233,876.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,418,004.24	144,062,577.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,144,827.00	65,870,150.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	54,863,720.00	32,541,980.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,141,900.00	30,083,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,139,207.00	3,244,370.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,273,177.24	78,192,427.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,273,177.24	78,192,427.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	30,065,100.00	78,965,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	30,065,100.00	78,965,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,065,100.00	78,965,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,065,100.00	78,965,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,065,100.00	78,965,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(30,065,100.00)	(78,965,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	131,285,372.76	8,526,221,571.52
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	131,285,372.76	8,526,221,571.52
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(457,132,321.75)	(457,132,321.75)
10	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	(475,765,183.98)	7,919,171,014.78
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	(475,765,183.98)	7,919,171,014.78
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(597,133,364.10)	(597,133,364.10)
18	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	(1,072,898,548.08)	7,322,037,650.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Төгрөгөөр

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,796,989,500.00	2,741,636,562.52	55,352,937.48	98.02
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,796,989,500.00	2,741,636,562.52	55,352,937.48	98.02
210	Бараа, үйлчилгээний зардал	2,730,476,300.00	2,675,766,412.52	54,709,887.48	98.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,048,733,700.00	2,009,231,705.76	39,501,994.24	98.07
210101	Үндсэн цалин	1,269,996,900.00	1,096,809,319.15	173,187,580.85	86.36
210102	Нэмэгдэл	588,016,900.00	562,994,086.80	25,022,813.20	95.74
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	68,623,500.00	79,171,859.65	(10,548,359.65)	115.37
210104	Урамшуулал	122,096,400.00	270,256,440.16	(148,160,040.16)	221.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	276,579,100.00	276,579,100.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	194,629,700.00	194,629,700.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,487,300.00	20,487,300.00	-	100.00
210203	УОМШӨ ний даатгал	16,389,900.00	16,389,900.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,097,500.00	4,097,500.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	40,974,700.00	40,974,700.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,976,500.00	83,976,499.76	8,000,000.24	91.30
210301	Гэрэл цахилгаан	27,191,400.00	32,429,914.62	(5,238,514.62)	119.27
210302	Тулш, халаалт	60,975,200.00	34,058,218.81	26,916,981.19	55.86
210303	Цэвэр, бохир ус	3,809,900.00	17,488,366.33	(13,678,466.33)	459.02
2104	Хангамж, бараа материалын зардал	26,720,500.00	28,681,966.00	(1,961,466.00)	107.34
210401	Бичиг хэрэг	3,118,700.00	3,112,931.00	5,769.00	99.82
210402	Тээвэр (шахахуун)	3,118,700.00	3,105,000.00	13,700.00	99.56
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,470,900.00	8,455,689.00	15,211.00	99.82
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,389,500.00	9,389,404.00	96.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,622,700.00	4,618,942.00	(1,996,242.00)	176.11
2105	Нормативт зардал	47,817,400.00	53,780,900.00	(5,963,500.00)	112.47
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	373,000.00	1,346,130.00	(973,130.00)	360.89
210502	Хоол, хүнс	45,172,400.00	50,169,680.00	(4,997,280.00)	111.06
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	2,272,000.00	2,265,090.00	6,910.00	99.70
2106	Эд хогшил худалдан авах	83,873,800.00	83,873,229.00	571.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,871,300.00	1,871,279.00	21.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,962,700.00	3,962,500.00	200.00	99.99
210604	Урсгал засвар	78,039,800.00	78,039,450.00	350.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	60,559,000.00	56,279,136.00	4,279,864.00	92.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,400,000.00	47,100,000.00	3,300,000.00	93.45
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	5,200,000.00	5,200,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,564,000.00	2,634,156.00	929,844.00	73.91
210804	Тээврийн хэрэгслийн татвар	495,000.00	462,230.00	32,770.00	93.38
210806	Мэдээллийн технологийн зардал	900,000.00	882,750.00	17,250.00	98.08
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	94,216,300.00	83,363,876.00	10,852,424.00	88.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	94,216,300.00	83,363,876.00	10,852,424.00	88.48
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,513,200.00	65,870,150.00	643,050.00	99.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,513,200.00	65,870,150.00	643,050.00	99.03
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	32,541,980.00	(32,541,980.00)	-
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,083,800.00	30,083,800.00	-	100.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	32,542,700.00	-	32,542,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,886,700.00	3,244,370.00	642,330.00	83.47
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,796,989,500.00	2,741,636,562.52	55,352,937.48	98.02
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,796,989,500.00	2,487,597,072.52	309,392,427.48	88.94
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,551,989,500.00	2,487,597,072.52	309,392,427.48	88.94
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	245,000,000.00	254,039,490.00	(254,039,490.00)	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	215,000,000.00	243,487,790.00	(243,487,790.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,000,000.00	10,551,700.00	(10,551,700.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	145	145	-	100.00
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	130	130	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	11	11	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

					Төгрөгөөр
Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	14,145,000.00	(14,145,000.00)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	14,145,000.00	(14,145,000.00)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	9,045,000.00	(9,045,000.00)	-
2105	Нормативт зардал	-	3,210,000.00	(3,210,000.00)	-
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	3,210,000.00	(3,210,000.00)	-
2106	Эд хогшил худалдан авах	-	5,835,000.00	(5,835,000.00)	-
210604	Урсгал засвар	-	5,835,000.00	(5,835,000.00)	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,100,000.00	(5,100,000.00)	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,100,000.00	(5,100,000.00)	-
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,100,000.00	(5,100,000.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	14,145,000.00	(14,145,000.00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	14,145,000.00	(14,145,000.00)	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	14,145,000.00	(14,145,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Үйлдвэрлэл Урлалын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Үйлдвэрлэл Урлалын политехник коллежийн захирал Д.Буяндэлгэр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг үнэн зөв хийж байх, төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журам зааврыг мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Азуре хүлүг аудит ХХК-ийн захирал Г.Мөнхбаяр, чанарын хяналтын менежер С.Оюунцэцэг, аудитор П.Энхтуяа, аудиторын туслах П.Болортуяа, Б.Тамир нар хариуцаж хэрэгжүүлэв.

Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газар болон Азуре хүлүг аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Өндөр шаардлага бүхий ажлын байрны эрэлтэд нийцсэн мэргэжлийн өндөр ур чадвар, дадал, зөв төлөвшилтэй мэргэжилтэн бэлтгэхэд" оршино.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн үйл ажиллагааны чиглэл нь мэргэжил эзэмшүүлэх, техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулах гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль;
- Засгийн газрын "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2019 оны 472 дугаар тогтоол;
- Засгийн газрын "Журам батлах тухай" 2019 оны 5 дугаар тогтоол;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" 2020 оны 49 дүгээр тогтоол.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Үйлдвэрлэл Урлалтын политехник коллежийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайланд онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тус коллежийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,172,531.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 31,725.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үйлдвэрлэл Урлалын политехник коллежийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 597,133.4 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	93,907.5	52,175.0	(41,732.5)
Бараа материал	352,627.5	313,270.4	(39,357.1)
Үндсэн хөрөнгө	7,472,636.0	6,956,592.2	(516,043.7)
Нийт хөрөнгө	7,919,171.0	7,322,037.6	(597,133.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,919,171.0	7,322,037.6	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,919,171.0	7,322,037.6	(597,133.4)

Авлага дансны эхний үлдэгдэл 93,907.5 мянган төгрөг байснаас тайлант онд 44,640.1 мянган төгрөгийн авлага шинээр үүсч, 86,372.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, эцсийн үлдэгдэл 52,175.0 мянган төгрөг болсон нь оюутны сургалтын төлбөрийн авлага байна.

Тус коллеж нь тайлант онд 105,709.1 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 145,066.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, бараа материал дансны үлдэгдэл 313,270.4 мянган төгрөг болж өмнөх үеэс 39,357.1 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал 122,023.5 мянган төгрөгийг, аж ахуйн материал 16,175.5 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалжээ. Тусгай зориулалтын

материал буюу хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд ашиглагдах сургалтын хэрэглэгдэхүүнийг 103,479.5 мянган төгрөгөөр худалдан авч, 122,023.5 мянган төгрөгийг зарцуулж, 244,919.9 мянган төгрөгийн хуримтлагдсан үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,956,592.2 мянган төгрөг болж 516,043.7 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А-1/148 тоот албан бичгээр зөвшөөрөл олгосны дагуу 52,860.2 мянган төгрөгийн үнэ бүхий 4 нэр төрлийн компьютер, тоног төхөөрөмж, 6,082.4 мянган төгрөгийн 2 төрлийн программыг акталсан, тайлант хугацаанд тооцоолсон 627,761.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Тус коллеж нь их засвар хийлгэж 76,680.2 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэлд тусгасан байна. Мөн 1,980.0 мянган төгрөгийн сургалтын жижиг оврын токарийн машин, 105.0 мянган төгрөгийн сандал, 200.0 мянган төгрөгийн ном, нийт 2,285.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамнаас хөтөлбөрийн хүрээнд 34,146.0 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлж авсан байна.

Тайлант онд аливаа өр төлбөр байхгүй байна.

Үйлдвэрлэл Урлалын политехник коллежийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 194,948.0 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан нь урсгал санхүүжилтийн орлого 210,047.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн хэдий ч төсөвт байгууллагын өөрийн орлого 333,597.1 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 71,398.5 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 102,892.9 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна. Тайлант онд байр ашиглахтай холбоотой зардал 35,356.9 мянган төгрөг, нормативт зардал 26,714.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 34,823.1 мянган төгрөг, томилолт, зочны зардал 2,710.2 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 87,576.4 мянган төгрөгөөр тус тус буурсан боловч цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 237,426.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 33,363.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 1,660.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 1,196.8 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 16,426.5 мянган төгрөгөөр тус тус өссөн нь үйл ажиллагааны зардал өсөхөд нөлөөлсөн байна.

Цалингийн зардал өссөн нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” -оор цалингийн хэмжээ өөрчлөгдсөн, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-аар ажилласан хугацааны нэмэгдэл олгосноос шалтгаалжээ.

Тайлант оны эцэст төрийн сангийн дансанд 78,192.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээс 73,092.4 мянган төгрөгийг урсгал төсвийн харилцахаас, 5,100.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,269,599.3 мянган төгрөгөөр, үүнээс улсын төсвөөс 3,064,599.3 мянган төгрөг, байгууллагын үйл ажиллагааны орлогоос 190,000.0 мянган төгрөг, туслах үйл

ажиллагааны орлогоос 15,000.00 мянган төгрөг, нийт зарлагыг 3,269,599.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 214,936.4 мянган төгрөгөөр бууруулан 3,054,662.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсөвт 1 удаа өөрчлөлт орж, 257,673.40 мянган төгрөгөөр бууруулж, 2,796,989.5 мянган төгрөг болгож тодотгосон байна.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 2,551,989.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 215,000.0 мянган төгрөгийг тус коллежийн үндсэн үйл ажиллагаанаас, 30,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,560,689.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 243,487.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 10,551.7 мянган төгрөг, нийт 2,814,728.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,741,636.5 мянган төгрөгийг зарцуулж, 73,092.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тус коллежийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 245,000.0 мянган төгрөг байсан ба 103.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 254,039.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,741,636.5 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь үндсэн болон нэмэгдэл цалингийн зардлыг 198,210.3 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 26,916.9 мянган төгрөгөөр, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 10,852.4 мянган төгрөгөөр, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардлыг 32,542.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн “Хөрөнгийн хуваарь батлах тухай” А/15 тоот тушаалаар их засварын 80,00.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлж баталсан. Үүний дагуу “Жэй энд Пи Жи” ХХК-г их засварын ажлыг гүйцэтгүүлэхээр сонгож гэрээ байгуулсан байна. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн боловч төсөв хүрэлцээгүйн улмаас их засварын 76,680.2 мянган төгрөгийн төсөв хасагдсан тул тайлант оны “гэрэл, цахилгаан”-ы зардлаас 21,241.6 мянган төгрөг, “түлш, халаалт”-ын зардлаас 26,789.5 мянган төгрөг, “Цэвэр, бохир ус”-ны зардлаас 8,790.0 мянган төгрөг, “хоол, хүнс”-ний зардлаас 19,859.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлж, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж нь сургуулийн цайны газар болон түргэн үйлчилгээний газрыг түрээслүүлж, түрээсийн орлого 782.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн боловч санхүүгийн үр дүнгийн тайланд 732.7 мянган төгрөгөөр тайлагнаж, түрээсийн орлогыг 50.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

“Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-т “Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүгийн 40 хувиар тогтоосугай” гэж заасны дагуу төвлөрүүлэх орлогын тооцооллыг хийж үзэхэд 93.2 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус коллеж нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого буюу оюутнуудаас суурь хураамж төвлөрүүлсэн 12,045.0 мянган төгрөг, спорт заалны төлбөр 1,000.0 мянган төгрөг, захиалгат сургалт зохион байгуулсны төлбөр 1,100.0 мянган төгрөг, нийт 14,150.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтээр бүрдүүлжээ.

Үүнээс нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд 3,210.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 5,835.0 мянган төгрөг, нийт 9,045.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,100.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 132 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээлэл, 5 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны цахим сайтад дараах мэдээллүүдийг байршуулаагүй байна.

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт,
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан бүтэн жилээр,
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан бүтэн жилээр,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг бүтэн жилээр,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 3 дугаар сард,

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээллийг 306,510.0 мянган төгрөгийн зөрүүтэй байршуулсан байна. Мөн харуул хамгаалалтын үйлчилгээг эрхлэх компанийг сонгон шалгаруулсан талаар худалдан авах ажиллагааны тайланд тусгаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 72,738.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 11,961.7 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэлтийн хувь		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	72,738.9	1	72,738.9	-	-	100
Зөвлөмж	2	11,961.7	2	11,961.7	-	-	100
Нийт дүн	3	84,700.6	3	84,700.6	-	-	100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 542,516.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 139,473.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 402,950.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 93.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлан дахь бусад авлагын дүнг авлагын тодруулгын дүнтэй тулгахад 52,175.0 мянган төгрөгөөр зөрснийг залруулав.
2. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хассан дүн нь Мөнгөн гүйлгээний тайлан дахь нийт цэвэр мөнгөн гүйлгээ 4,599.0 мянган төгрөгөөр зөрснийг залруулав.
3. Санхүүгийн байдлын тайлан дахь хүнсний материалын дансны үлдэгдлийг бараа материалын тодруулгын тайлан дахь дүнтэй тулгахад 51,294.0 мянган төгрөгөөр зөрснийг залруулав.
4. Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан гүйцэтгэж, шалгагдагч этгээдийн элэгдлийн дүнтэй тулгахад 6,259.8 мянган төгрөгөөр зөрүү үүссэнийг залруулав.
5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан батлагдсан төсвийн хуваарь хоорондоо зөрсөн алдааг тулган шалгаж баталгаажуулан 25,415.6 мянган төгрөгөөр залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 402,950.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим сайтад 2020 оны 2 дугаар сард 1 мэдээллийг, 7 дугаар сард 3 мэдээллийг, 8 дугаар сард 1 мэдээллийг, 1 дүгээр улиралд 1 мэдээллийг, бүтэн жилээр оруулах 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. 6 мэдээллийг байршуулаагүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг 306,510.0 мянган төгрөгийн зөрүүтэй байршуулсан байна. Харуул хамгаалалтын үйлчилгээг эрхлэх компанийг сонгон шалгаруулсан талаар худалдан авах ажиллагааны тайланд тусгаагүй байна. Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/97 тоот тушаалаар ажилтанд 96,440.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай журам”-ын 4.6-д “Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно”, 2019 оны 382 дугаар тогтоолын 2-т “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 93.2 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай холбоотойгоор аудитын явцад бараа материалын тооллогыг биечлэн хийх, тулган баталгаажуулах боломжгүй байсан тул тусгай зориулалттай бараа материалын үлдэгдэл, шинээр бэлтгэх болон зарцуулалт, дадлагын хичээлийн үр дүнд бий болгосон бүтээгдэхүүнийг орлогод авч нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан эсэхийг хянах боломжгүй байсан тул дараагийн аудитаар энэ талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төвлөрүүлэх орлоготой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлэх түрээсийн орлогын төлбөрийг 93.2 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-т “Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүгийн 40 хувиар тогтоосугай” гэж заасантай нийцээгүй байна.

1.2. Эрсдэл: Төвлөрүүлэх орлогыг дутуу тайлагнах,

1.3. Өгсөн зөвлөмж: Түрээсийн орлогоос Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлэх түрээсийн орлогын төлбөрийг орлогыг хүлээн авсан тухай бүр шилжүүлж, үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаж ажиллах

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой

2.1. Илрүүлэлт: Аудитын явцад үндсэн хөрөнгийн бүртгэлийг түүвэрлэн шалгаж, биет горим гүйцэтгэхэд өөрийн барьсан 1 гражийг бүртгэлд тусгаагүй нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 -т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ гэж заасантай нийцээгүй байна.

2.2. Эрсдэл: Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дутуу тайлагнагдах

2.3. Өгсөн зөвлөмж: Байгууллага өөрийн барьсан машины гражийн үнэлгээг УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-д заасны дагуу хийж, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар баталгаажуулан өртгийг тодорхойлж, бодит байх, үнэн зөв, эрх бар үүрэг батламж мэдэгдлийг хангаж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Үйлдвэрлэл Урлалын политехник коллежийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/313/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/97 тоот тушаалаар мөнгөн шагнал олгосон нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчимтай нийцээгүй байна.	96,440.0	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Буяндэлгэр Б.Хонгорзул
2	Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 6 мэдээллийг огт байршуулаагүй байна.	306,510.0	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Д.Буяндэлгэр Б.Хонгорзул
3	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлэх түрээсийн орлогын төлбөрийг дутуу төвлөрүүлсэн байна.	93.2	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Буяндэлгэр Б.Хонгорзул
4	Үндсэн хөрөнгийн бүртгэлд түүвэрлэн тооллого хийхэд өөрсдөө аж ахуйн аргаар барьсан нэг машины гражийг бүртгэлд аваагүй байна.	0.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Буяндэлгэр Б.Хонгорзул
ДҮН		403,043.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 19/A0160002

Улаанбаатар хот

САГ-2021/313/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үйлдвэрлэл Урлалын политехникийн коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/97 тоот тушаалаар багш, ажилтанд 96,440.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал, урамшуулал олгосон, мөн байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах 149 мэдээллээс 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг огт байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг 306,510.0 мянган төгрөгийн зөрүүтэй байршуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай журам"-ын 4.6-д "Төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчид үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ыг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.",

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0225auditin 2-R_Gazar19.Docx

.*

001081081

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн
ШААРДАХ нь:

1. Төсвийн захирагч нь цаашид тушаал шийдвэр гаргахдаа Засгийн газрын тогтоол шийдвэрийг мөрдөж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроож байршуулсан зэрэг зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн захирал Д.Буяндэлгэр, нягтлан бодогч Б.Хонгорзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.ЭНХЖИН

Г.МӨНХБАЯР

